

**Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа
байгууллагуудаас хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж,
зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ**

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах, хяналт тавьдаг. Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 354 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмаар зохицуулагддаг бөгөөд тус журмын 5.1.3-т заасны дагуу харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн татварын дараах цэвэр ашгийн 3 хувь байна. Харилцах дансны дугаар: Төрийн банк MN660090100900010033

“Үндэсний дата төв” УТҮГ-ын үйлчилгээний мэдээлэл

1.Мэдээллийн технологийн зориулалтын орчин нөхцөлд байршуулсан серверийн зогсуур /rack/-т хэрэглэгчид өөрийн сервер тоног төхөөрөмжөө байршуулан ашиглах боломжийг олгож буй үйлчилгээ юм.

Үйлчилгээ авах шат дараалал:

- Төрийн байгууллага:
 - Үйлчилгээ авах хүсэлтээ манай байгууллагад албан бичгээр илгээнэ./Албан бичиг дээр хариуцах ажилтны утасны дугаар болон э-мэйл хаягийг тусгасан байх шаардлагатай. Мөн серверийн тодорхой мэдээллийг албан бичиг нь дээрээ бүрэн гүйцэд тусгах/
 - Тухайн үйлчилгээг хариуцсан мэргэжилтэн тантай холбогдож гэрээний төсөл илгээх бөгөөд танд тус үйлчилгээний талаар тодорхой мэдээллийг өгөх болно.
 - 2 талаас гэрээ байгуулагдаж эцэслэн баталж зурагдсаны дараа манай байгууллагад серверээ байршуулна.
- Хувийн байгууллага:
 - Үйлчилгээ авах хүсэлтээ манай байгууллагад албан бичгээр илгээнэ./Албан бичиг дээр хариуцах ажилтны утасны дугаар болон э-мэйл хаягийг тусгасан байх шаардлагатай. Мөн серверийн тодорхой мэдээллийг албан бичиг нь дээрээ бүрэн гүйцэд тусгах/
 - Тухайн үйлчилгээг хариуцсан мэргэжилтэн тантай холбогдож гэрээний төсөл илгээх бөгөөд танд тус үйлчилгээний талаар тодорхой мэдээллийг өгөх болно.
 - 2 талаас гэрээ байгуулагдаж эцэслэн баталж зурагдсаны дараа манай байгууллагад серверээ байршуулна.
 - Үйлчилгээний сарын төлбөрийг сарын эхэнд манай байгууллагын данс руу шилжүүлнэ.

Харилцах дансны дугаар: Төрийн банк 100900010034 (гүйлгээний утга: Байгууллагын регистрийн дугаар, байгууллагын нэр, авч буй үйлчилгээ).

Төрийн байгууллагаас бусад хүн, хуулийн этгээд нь Төрийн мэдээлэл солилцооны систем болон Танилт нэвтрэлтийн систем хэрэглэгчид billing.datacenter.gov.mn цахим хуудсаар нэвтэрч өөрийн байгууллагын төлбөрийн мэдээлэл, нэхэмжлэхийг харах боломжтой. Хэрэглэгч та үйлчилгээний төлбөрийг тухайн сарын 20-ны өдрийн дотор төлөөгүй бол үйлчилгээ хаагдахыг анхаарна уу.

Зогсуур түрээс үйлчилгээний төлбөрийг customer.datacenter.gov.mn цахим хуудсанд нэвтэрч төлбөрийн задаргааг харах боломжтой.

2. Монголын интернетийн харилцан холболтын үйлчилгээ /МИХХ/

Монголын интернэтийн харилцан холболт гэж дотоодын интернэт урсгалыг солилцуулах зорилгоор Монголын интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хооронд холбосон дэд бүтэц бүхий сүлжээний холболт юм. Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжид холбогдсоноор Монголын интернэтийн үйлчилгээ үзүүлдэг /ISP-Internet service provider/ байгууллагууд мөн тэдгээрийн хэрэглэгчид Монгол дотроо хурдны хязгаарлалтгүйгээр өндөр хурдаар өгөгдөл, мэдээлэл солилцох боломж бүрдэнэ. Мөн МИХХ-д холбогдсоноор интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дараах үйлчилгээнүүдийн хурд нэмэгдэж, чанар сайжирна.

МИХХ-ын үйлчилгээнд хэрхэн холбогдох вэ?

2.1.Тус төвд МИХХ-т холбогдох хүсэлтээ албан бичгээр ирүүлэх ба ХХЗХ-ны зөвшөөрлийг хавсаргасан байна.

2.2.Тус төвөөс гаргасан техникийн нөхцөлийн дагуу бэлтгэл ажлыг хангасан байна.

2.3.“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-д хүсэлт гарган шилэн кабель татах техникийн нөхцөл гаргуулсан байх ба шилэн кабелийн өрөөнд өөрийн шилэн кабелийн үзүүрийг оруулсан байна.

2.4.Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжид холбох 10 метрийн шилэн кабелийн хос жампер бэлтгэх /МИХХ-ын төхөөрөмжид холбогдох тал нь SC толгойтой байх/

3.“ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем

Төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний платформоор дамжин хүрэх үйлчилгээ.

Монгол Улс бие даасан төрийн мэдээлэл солилцооны системтэй болох, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, хялбаршуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/61 тоот тушаалаар баталсан “Төрийн мэдээлэл солилцооны системийн талаар баримтлах бодлогын чиглэл”-ийн хүрээнд нээлттэй эхийн платформ дээр суурилсан, “Enterprise Service Bus” архитектуртай “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг тус төвөөс хөгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү систем нь мэдээллийг хоёр төрийн байгууллага хооронд шууд солилцдог, мэдээллийн санг хуулбарлаж, шинэчлэх байдлаар үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын үйлчилгээний уламжлалт шийдлийг бүрэн халж, мэдээллийг илүү уян хатан шийдэлтэйгээр шуурхай, аюулгүй, найдвартай харилцан солилцуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа билээ. Тус системд хувийн байгууллагууд ч холбогдох боломжтой бөгөөд энэ нь иргэд төрийн байгууллага болон бусад үйлчилгээний байгууллагуудаас үйлчилгээ авахад шаардаглагатай лавлагаа, тодорхойлолтуудыг бүрдүүлэхэд учирдаг хүндрэлүүдийг бүрэн арилгахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

Иргэдийн хамгийн их үйлчилгээ авдаг байгууллагуудыг нэн тэргүүнд "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системд холбох бөгөөд ХУР системд холбогдох мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу: <https://developer.xyp.gov.mn>

Үйлчилгээ авах шат дараалал:

Шинээр үйлчилгээнд холбогдох бол

- “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам”-д үйлчилгээ авах хүсэлтээ албан бичгээр илгээнэ.
- “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам”-тай байгуулсан гэрээнд үндэслэн төрийн байгууллага болон хувь хүн, хуулийн этгээдийн холболтыг Үндэсний Дата Төв хийнэ.

Сервис нэмэх бол:

- Гэрээ байгуулсан байгууллагууд сервис нэмүүлэх токений мэдээллийг сервисийн жагсаалтын (WS100... гэх мэт) хамтаар албан хүсэлтээр Үндэсний Дата Төвд ирүүлнэ.

Заавар зөвлөмж:

<https://developer.xyp.gov.mn> цахим хуудаснаас веб сервисийн жагсаалт, холбогдох заавар, системд холбогдох, гэрчилгээ нэмэх, тохиргоо шалгах веб сервис дуудах, клиент жишээ кодуудыг харах боломжтой. Шаардлагатай тохиолдолд санал хүсэлт, алдааны мэдээллээ хавсаргаад info@datacenter.gov.mn цахим шууданд илгээнэ үү.

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар

1161

Улаанбаатар хот

Зарим үйлчилгээний үнэ, тарифыг
шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 тоот тушаалаар баталсан "Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.15, дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 06/1266 тоот албан бичгийн дагуу "Үндэсний дата төв" УТҮГ-ын Захирлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/36 тоот тушаалын хавсралтаар баталсан "Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ" болон "Зогсуур түрээсийн үйлчилгээний" үнэ, тарифыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Тус төвөөс үйлчилгээ авч буй хуулийн этгээдүүдэд мэдэгдэл хүргэн, гэрээ шинэчлэн байгуулан ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн Хэрэглэгчийн үйлчилгээний мэргэжилтэн (Д.Энхтөгс)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс (Ж.Нямгэрэл)-т даалгасугай.

Дөрөв. "Үндэсний дата төв" УТҮГ-ын Захирлын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/36 тоот тушаалын хавсралтаар баталсан "Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ" болон "Зогсуур түрээсийн үйлчилгээний" үнэ, тарифыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



М.БАТТУЛГА

"Үндэсний Дата Төв" УТҮГ-ын захирлын
2023 оны 06 сарын 14 өдрийн
А.А. Тоот тушаалын хавсралт

**Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үзүүлэх
үйлчилгээний үнэ,тариф**

1. Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ	Портын тоо(ETH/SPF/SPF+)	Cap	100,000₮
Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ	Портын тоо(QSFP+/QSFP28)	Cap	300,000₮
Холболтын хураамж/нэг удаагийн/			200,000₮

2. Зогсуур түрээсийн үйлчилгээ

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Зогсуур түрээсийн үйлчилгээ	1 UNIT	Cap	50,000₮
Зогсуур түрээсийн үйлчилгээ	1 RACK (42 UNIT)	Cap	1,100,000₮
Нэмэлт үйлчилгээ IP хаяг	1ширхэг	Cap	5,000₮

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын үйлчилгээний мэдээлэл

1.Орчуулгын төхөөрөмж түрээсийн үйлчилгээ

Дуу тусгаарлах кабин, орчуулагчийн ажиллах пульт, үүнтэй холбогдсон микрофон, чихэвч байдаг. Пульт нь хурлын үндсэн яриа болон бусад орчуулагчдаа (6 сувгаасаа) сонсож орчуулах, сонсож байгаа дууны сигналын түвшингээ өөрөө тохируулах боломжоор хангагдсан байдаг. Хурлын үндсэн яриа нь ямар ч хэлээр ярьж болох учраас бусад орчуулагчдаа сонгож сонсдог.

Улсын их баяр наадмын хурдан морьдын уралдааны барианы газар “Хүй долоон худаг” болон төв цэнгэлдэх хүрээлэнгийн радио узель, дууны өсгөгчийг жил бүр ажиллуулж ирсэн найдвартай тоног төхөөрөмж, туршлагатай инженер техникийн ажилчид зөөврийн өсгөгчөөр үйлчилнэ. Орчуулгын төхөөрөмж захиалга хүлээн авах хүсэлт гаргах /хэдийд ямар хугацаатай ашиглах, хуралд оролцогчдын тоо, ашиглах сувгийн тоо, хаана суурилуулах/ зэргийг тодорхой дурдсан байна. Цахим шуудан, факс болон албан бичгээр хүсэлт гаргаж болно.

Үнэ тариф:

1. Зөөврийн радио зангилаа

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф /₮/
1	100 Вт хүртэл чадалтай	Цаг	35 000
2	100-300 Вт хүртэл чадалтай	Цаг	70 000
3	300-600 Вт хүртэл чадалтай	Цаг	85 000
4	600-1500 Вт хүртэл адалтай	Цаг	120 000
5	1500 Вт-аас дээш	Цаг	250 000

2. Орчуулгын төхөөрөмж

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф /₮/
1	Орчуулгын төхөөрөмж /үндсэн суваг/	Цаг	45 000
2	Орчуулгын төхөөрөмж /2-4 суваг/	Үндсэн суваг + суваг /цаг/	35 000
3	Чихэвчийн үнэ	Цаг /нэг бүрийн үнэ/	1 000
4	Техникийн ажлын хөлс	50 хүртэл чихэвчтэй	50 000
		51-100 хүртэл чихэвчтэй	75 000
		101-150 хүртэл чихэвчтэй	100 000
		151-200 хүртэл чихэвчтэй	125 000
		201-250 хүртэл чихэвчтэй	150 000
		251-300 хүртэл чихэвчтэй	175 000
		301-350 хүртэл чихэвчтэй	200 000
		351-400 хүртэл чихэвчтэй	225 000
		401-450 хүртэл чихэвчтэй	250 000
		451-500 хүртэл чихэвчтэй	275 000
		501-ээс дээш чихэвчтэй	300 000
5	10-20 микрофон ажиллуулах	Цаг	50 000

Тайлбар: Хотын төвөөс 30 км-ээс дээш зайд зөөврийн радио зангилаа, орчуулгын төхөөрөмжийг захиалгаар ажиллуулах тохиолдолд төхөөрөмж тээвэрлэх тээврийн зардал, инженер техникийн ажилтан нарын байр, хоолны зардлыг захиалагч байгууллага хариуцна.

Харилцах дансны дугаар: Төрийн банк 340003159704

2.Үүрэн операторын компани болон бусад үйлчилгээний газруудад тухайн үйл ажиллагаатай холбоотой антен, тоног төхөөрөмжүүдийг Улаанбаатар хот, хөдөө орон нутагт байрших өөрийн эзэмшлийн байр, цамхагтаа байршуулан эрчим хүчээр хангаж **байр талбайн түрээсийн үйлчилгээ** үзүүлж байна.

1.1 Сайтын байршлуудын мэдээлэл

1.2. Цамхгуудын байршлуудын мэдээлэл

1.3. Түрээсийн үйлчилгээний тарифын мэдээлэл

Үйлчилгээ авах хүсэлт гаргахдаа байрлуулах тоног төхөөрөмжийн 3 хэмжээст хэмжээ, эрчим хүч хэрэглэх чадал, татах кабел болон антены төрөл зэргийг тодорхойлсон албан бичгийг цахим шуудан болон факсаар ирүүлнэ. Бид таны хүсэлтийн дагуу үйлчилгээний техникийн нөхцөл гаргаж гэрээ байгуулснаар үйлчилгээ авах боломжтой болно.

Харилцах дансны дугаар: Төрийн банк 340003159704